

**“ТҮР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд зэ,

Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурал энэ хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Түр хороог Улсын Их Хурлын бүх Байнгын хорооны болон Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулахаар хуульчилсан.

Дээрх хуулийн биелэлтийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо”-г байгуулж, бүрэлдэхүүнийг нь шинэчлэн баталсан билээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолоор “Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах шаардлага үүссэн болно.

Иймд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг үндэслэн “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа уг тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн ач холбогдол буурсан, дэлхий дахинд цар тахлын өвчлөл багасч, нөхцөл байдал сайжирч байгаа тул уг хуулийг хүчингүй болгох, цар тахлаас үүдэн эдийн засгийн нөхцөл байдал нь хүндэрсэн аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг сэргээх, дэмжлэг үзүүлэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Б.Баттөмөр нар Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн ач холбогдол багассантай санал нэг байгаагаа илэрхийлээд, хуулийг хүчингүй болгох тухай асуудлыг хөндөхөөсөө өмнө Түр хороо үйл ажиллагаандaa үнэлэлт, дүгнэлт өгч, хуулийн хэрэгжилтийн алдаа оноо, зөрчил, амжилттай тал зэргийг дүгнэх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа тул Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах шаардлагагүй гэсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж, батлах нь зүйтэй гэж үзэж байгаагаа илэрхийлээд, тухайн хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаа, гарсан алдаа дутагдал, зөрчлийг нэгтгэн дүгнэсний дараа Түр хорооны үйл ажиллагааг дуусгах, Засгийн газраас уг хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслөө Улсын Их Хуралд өргөн барих шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн дээрх хууль нь цар тахлын үед үүргээ гүйцэтгэсэн бөгөөд цаашид онцгой, гэнэтийн нөхцөл байдал үүссэн үед хэрэглэх Онцгой байдлын үед авах арга хэмжээний тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн барих талаар Засгийн газарт чиглэл өгөх, онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх нөөцийн бэлэн байдлыг хангах, бүрдүүлэх, шаардлагатай үед тухайн нөөцөөрөө хүнд үеийг даван туулах нь зүйтэй гэлээ.

“Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

### **Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дэх заалтад заасан Түр хорооны бүрэлдэхүүнийг доор дурдсанаар шинэчлэн баталсугай:

#### **Түр хорооны дарга:**

Б.Баттөмөр	Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга
------------	---

#### **Түр хорооны гишүүд:**

Б.Энх-Амгалан	Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга
---------------	---

Б.Саранчимэг	Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга
--------------	---

Г.Мөнхцэцэг	Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга
-------------	---

Э.Батшугар	Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга
------------	---

П.Анужин	Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга
----------	---

Ж.Мөнхбат	Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
-----------	---

Г.Тэмүүлэн	Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга
------------	---

Т.Энхтүвшин	Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга
Л.Мөнхбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
Ц.Цэрэнпүнцаг	Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
Б.Байсен	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн төлөөлөл
С.Ганбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Та бидний эвсэл”-ийн төлөөлөл
Т.Доржханд	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Зөв хүн электорат эвсэл”-ийн төлөөлөл

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг